

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/69/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
[www.audit.mn](#)
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээт аудитор: С.Алтанхундага
Утас: 70453799, Цахим хаяг: S_Altanhundaga@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
5.1 Залруулсан алдаа	
5.2 Төлбөрийн акт	
5.3 Албан шаардлага	
5.4 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрамын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА М.ТҮВШИНБАЯР ТАНАА

2022.02.14 № УВА-2023/69/НА.СТА.ТЦЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/11 дүгээр захирамжаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга томилогдсон байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700531

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	919,000	919,000
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	919,000.00	919,000.00
354	Хангамжийн материал	919,000.00	919,000.00
35410	Бичиг хэргийн материал	197,000.00	197,000.00
35420	Аж ахуйн материал	722,000.00	722,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,336,524.33	4,106,924.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,336,524.33	4,106,924.74
392	Биет хөрөнгө	5,336,524.33	4,106,924.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,759,800.00	4,259,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-699,999.56	-1,577,449.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,097,500.00	9,097,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,820,775.71	-7,672,925.34
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,336,524.33	4,106,924.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,255,524.33	5,025,924.74
51	Засгийн газрын хувь оролцоо	6,255,524.33	5,025,924.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,350,000.00	3,350,000.00
51101	Өмч: - төрийн	3,350,000.00	3,350,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,905,524.33	1,675,924.74
51210	Өмнөх үеийн үр дүн	2,905,524.33	2,905,524.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,229,599.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,255,524.33	5,025,924.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүн

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	76,221,800	105,299,200
11	ТАТВАРЫН ОРЛОГО	76,221,800	105,299,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,406,800	105,299,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,406,800	105,299,200
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	74,501,617.11	106,528,799.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,501,617.11	106,528,799.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,043,251.47	66,908,264.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,603,854	43,934,317
210101	Үндсэн цалин	36,266,513	28,298,056

210102	Нэмэгдэл		5,267,450
210104	Урамшуулал	9,337,341	10,368,811
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,456,990.36	5,237,157.48
210201	Тэтгэврийн даатгал	4,099,708.87	3,734,426.07
210202	Тэтгэмжийн даатгал	456,038.54	439,343.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	364,830.95	351,474.64
210204	Ажилгүйдлийн даатгал	49,570.38	63,508.74
210205	Эрүүл мэндийн даатгал	486,841.62	648,404.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3,478,570	3,774,820
2104	Хангамж, бараа материалын зардал	3,478,570	3,774,820
210401	Бичиг хэрэг	591,900	961,100
210402	Тээвэр, шатахуун	2,640,170	2,582,520
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	246,500	231,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,008,600	333,500
210604	Урсгал засвар	1,008,600	333,500
2107	Томилолт, зочны зардал	571,000	286,000
210702	Дотоод албан томилолт	571,000	286,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	144,000	1,144,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,000,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000	144,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,780,237.11	12,198,469.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,924,620	4,637,370
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,620,000	5,831,500
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,235,617.11	1,729,599.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,458,365.64	39,620,535.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,583,200	35,925,500
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,905,500
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,270,000	4,020,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,875,165.64	3,695,035.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,875,165.64	3,695,035.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	1,720,182.89	-1,229,599.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,720,182.89	-1,229,599.59

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	76,221,800	105,299,200
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,221,800.00	105,299,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000	

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,406,800	105,299,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,406,800	105,299,200
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	76,221,800	105,299,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,221,800	105,299,200
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,763,434.36	65,678,664.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,603,854	43,934,317
210101	Үндсэн цалин	36,266,513	27,737,118
210102	Нэмэгдэл		5,828,388
210104	Урамшуулал	9,337,341	10,368,811
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,456,990.36	5,237,157.48
210201	Тэтгэврийн даатгал	4,099,708.87	3,734,426.07
210202	Тэтгэмжийн даатгал	456,038.54	439,343.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	364,830.95	351,474.64
210204	Ажилгүйдлийн даатгал	49,570.38	63,508.74
210205	Эрүүл мэндийн даатгал	486,841.62	648,404.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3,478,570	3,774,820
2104	Хангамж, бараа материалын зардал	3,478,570	3,774,820
210401	Бичиг хэрэг	591,900	961,100
210402	Тээвэр, шатахуун	2,640,170	2,582,520
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	246,500	231,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,928,400	333,500
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,709,800	
210602	Тавилга	1,210,000	
210604	Урсгал засвар	1,008,600	333,500
2107	Томилолт, зочны зардал	571,000	286,000
210702	Дотоод албан томилолт	571,000	286,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	272,000	1,337,400
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,000	1,193,400
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000	144,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,626,220	10,968,870
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,006,220	5,137,370
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,620,000	5,831,500
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,458,365.64	39,620,535.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,583,200	35,925,500
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200	31,905,500
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,270,000	4,020,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,875,165.64	3,695,035.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,875,165.64	3,695,035.52

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөг/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,350,000		1,387,266.44		4,737,266.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,350,000		1,387,266.44		4,737,266.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн			-201,925		-201,925
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,350,000		2,905,524.33		6,255,524.33
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл					
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,350,000		2,905,524.33		6,255,524.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		-1,229,599.59		-1,229,599.59

D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,350,000	1,675,924.74	5,025,924.74
-----	--	-----------	--------------	--------------

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,299,200	101,604,164.48	3,695,035.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,299,200	101,604,164.48	3,695,035.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,357,100	65,678,664.48	3,678,435.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,658,900	43,934,317	2,724,583
210101	Үндсэн цалин	36,616,500	27,737,118	8,879,382
210102	Нэмэгдэл		5,828,388	-5,828,388
210104	Урамшуулал	10,042,400	10,368,811	-326,411
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,832,200	5,237,157.48	595,042.52
210201	Тэтгэврийн даатгал	3,966,000	3,734,426.07	231,573.93
210202	Тэтгэмжийн даатгал	466,600	439,246.50	27,353.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	373,200	351,397.30	21,802.70
210204	Ажилгүйдлийн даатгал	93,300	63,508.74	29,791.13
210205	Эрүүл мэндийн даатгал	933,100	648,578.87	284,521.13
2104	Хангамж, бараа материалын зардал	3,813,900	3,581,420	232,480
210401	Бичиг хэрэг	767,700	767,700	
210402	Тээвэр, шатахуун	2,583,000	2,582,520	480
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	463,200	231,200	232,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	333,500	333,500	
210604	Урсгал засвар	333,500	333,500	
2107	Томилолт, зочны зардал	360,200	286,000	
210702	Дотоод албан томилолт	360,200	286,000	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,386,700	1,337,400	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,242,700	1,193,400	49,300
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000	144,000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,971,700	10,968,870	2,830
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,138,700	5,137,700	1,330
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,833,000	5,831,500	1,500
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,942,100	35,925,500	16,600
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,905,500	31,905,500	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,036,000	4,020,000	16,600
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	105,299,200	101,604,164.48	3,695,035.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,299,200	101,604,164.48	3,695,035.52

132001	Орон нутгийн төсвөөс	105,299,200	101,604,164.48	3,695,035.52
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
610001	Төсвийн байгууллага	1	1	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Монгол улсын үндсэн хууль Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхыг дээшлүүлэн иргэдийн төлөөллөөрөө дамжуулан нутаг дэвсгэрийнхээ иргэдийн хүсэл сонирхол, эрх ашгийг дээдэлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангаж, сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг иргэдийн оролцоотой тодорхойлох гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр

- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,229.9 мянган төгрөгөөр бууу 0.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	919.0	919.0	0.0
Үндсэн хөрөнгө	5,336.5	4,106.9	-1,229.6
Нийт хөрөнгө	6,255.5	5,025.9	-1,229.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,255.5	5,025.9	-1,229.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,255.5	5,025.9	-1,229.6

Бараа материалын дансны үлдэгдэл 919.0 мянган төгрөг байгаа нь бараа материал дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,025.9 мянган төгрөг болж 1,229.6 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмжийн хөрөнгө нэмэгдэж, хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалж буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,025.9 мянган төгрөг болж 1,229.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 122,168.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 16,869.0 мянган төгрөгийг хасаж 105,299.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 105,299.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 105,299.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 101,604.2 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3,695.0 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	53,857.4	50,190.1	3,667.3	93,2%
2	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Мэдээлэл сурталчилгааны зардал-80205	193.4	193.4	0,00	100%
3	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	35,942.1	35,925.5	16,6	99,9%
4	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Багийн ИНХ-ын даргын урамшуулал-80825	11,297.6	11,287.7	9,8	99,9%
5	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70105: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх-82201	4,008.7	4,007.4	1,3	99,9%

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь албан хаагч ажлаас чөлөөлөгдсөнөөс шалтгаалан 3,319.6 мянга, шуудан холбооны зардал 232.0 мянга, дотоод албан томилолт 74.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 49.3 мянган төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор тус тус хэмнэсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор С.Алтанхундага гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,146,382.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,463.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,361,778.4 төгрөгийн 1 хувиар буюу 13,617.7 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс, мэдээлэл байршуулаагүй 2, хугацаандаа мэдээлсэн 117 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цагаанхайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР  /С.АЛТАНХУНДАГА/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр